

## “MIND UPDATE” ТӨСЛИЙН ХУВЬ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2023.03.29

Дархан-Уул аймаг

JCI Их Хүрээ салбараас санаачлан хэрэгжүүлж буй “MIND UPDATE” төслийг БШУЯ, Соёлын яам дэмжин сурагчдад сэтгэлгээгээ өөрчлөх, хувь хүний хөгжил, байгаль дэлхийгээ хайрлах, өөрийн дотоод мөн чанар, өөрийгөө олж нээх боловсрол олгох зорилгоор 21 аймагт хэрэгжүүллээ. Тус төслийн хүрээнд Дархан-Уул аймаг нь 19 дэх аймаг болж хувь хүний хөгжлийн сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Залуучууд театрт зохион байгуулав.




Үйл ажиллагааны эхэнд аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан төсөл хэрэгжүүлэгчдэд болон сурагчдад Хязгааргүй боломжийг хамтдаа нээхийг уриалж сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүслээ.

### Сургалтаар:

1. Нүүдэл
2. Хайрын 5 хэл
3. Мэргэжилдээ хэрхэн эзэн болох вэ?
4. Ногоон ирээдүй
5. Сэтгэлгээний өөрчлөлт зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж нээлттэй ярилцлаа.

Сургалтад ерөнхий боловсролын ахлах ангийн нийт 500 орчим сурагч хамрагдаж үр өгөөжтэй сургалтад хамрагдсандаа талархал илэрхийлж сэтгэгдэл өндөр байгаагаа сургалтын төгсгөлд хуваалцлаа.

Зохион байгуулагчаар: Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар ажиллаж Дархан-Уул Аймаг, Дархан-Уул аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Залуучууд театр, Мэдээлэл технологийн алба, ЕБС-ийн багш, нийгмийн ажилтнууд хамтран ажиллалаа.



ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУЯА

ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛ, УРЛАГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЧИНБИЛЭГ